



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/248

Булган

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17.1.3 дахь заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 6.1.3, 10.1.4, 11.1.2, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 239-р тушаалаар батлагдсан аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрийн 1.5.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хүүхэд багачуудын хүсэл сонирхлыг дэмжин ирээдүйн урлагийн замыг нээх, үндэсний өв соёлыг таниулах, сурталчлах зорилгоор "Булган хангайн хүүхдүүд" урлагийн наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.


2. Урлагийн наадмыг зохион байгуулахад шаардагдах 4500000 /дөрвөн сая таван зуун мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөнөөс хавсралтын дагуу гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс /О.Наранжаргал/-т зөвшөөрсүгэй.

3. Урлагийн наадмыг амжилттай зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс /Э.Түвшинмөнх/-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  З.БАТЗОРИГ



168  
Аймгийн Засаг даргын 2018 оны 04 дугаар сарын 05  
өдрийн 184 тоот захирамжийн хавсралт



БУЛГАН ХАНГАЙН ХҮҮХДҮҮД-2018 УРЛАГИЙН НААДМЫГ ЗОХИОН  
БАЙГУУЛАХАД ШААРДАГДАХ ТӨСӨВ

№	Шаардагдах зардал	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт
1.	ХЖТ-ын заал, техник хэрэгслийн түрээс	2 өдөр	250000	500000
2.	Урлагийн наадмыг шүүх шүүгчдийн урамшуулал	2 хүн	200000	400000
3.	Уралдаанд оролцогсдын шагнал, урамшуулал /уралдааны төрөл, насны ангилал тус бүрээр 1, 2, 3-р байр/	10 төрөл, 3 насны ангиллаар	-	3600000
	Дүн			4500000